2.10.1.22	Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах	Үйл ажиллагаа	Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа	Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтын VPN сүлжээ, хиймэл дагуулын мэдээ хүлээн авах станц, сумдын даамлуудад ашиглагдаж буй гэр интернет төхөөрөмжийн хэвийн үйл	Эхний хагас жилд: Салбарын тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна. Жилийн эцэст: Салбарын тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний	Байгууллагын дотоод сүлжээ болон ГЗБГЗЗЕГ-азартай холбогдсон тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтын VPN сүлжээ, хиймэл дагуулын мэдээ хүлээн авах станц, сумдын даамлуудад ашиглагдаж буй гэр интернет төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган, шаардлагатай тохиолдолд ГЗБГЗЗЕГ-ын Мэдээлэл	100

				ажиллагааг ханган ажилласан.	аюулгүй, хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна.	технологийн хэлтэс болон Unitel-тэй холбогдож, арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулж ажилладаг.	
2.10.1.23	Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийх, хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээлэл оруулах ажлыг хариуцсан албан хаагчтай хамтран гүйцэтгэх	Үйл ажиллагаа	Байгууллагын цахим хуудсын нэмэлт хөгжүүлэлт, оруулсан мэдээллийн тоо	-Байгууллагын цахим хуудсанд мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулсан.	Эхний хагас жилд: - Байгууллагын цахим хуудсын шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж, хэвийн үйл ажиллагааг хангасан байна. - Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл оруулах ажлыг хариуцсан албан хаагчтай хамтран гүйцэтгэсэн байна. - Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсын өөрийн байгууллагын хамаарах хэсэгт мэдээлэл оруулах ажлыг хариуцсан албан хаагчтай хамтран гүйцэтгэсэн байна. Жилийн эцэст: - Байгууллагын цахим хуудсын шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж, хэвийн үйл ажиллагааг хангасан байна. - Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл оруулах ажлыг хариуцсан албан хаагчтай хамтран гүйцэтгэсэн байна. - Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсын өөрийн байгууллагын хамаарах хэсэгт мэдээлэл оруулах ажлыг хариуцсан албан хаагчтай хамтран гүйцэтгэсэн байна.	Байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/ болон facebook дахь хуудас /Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/-д байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан сурталчилж байна. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр 150 гаруй мэдээ, мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудас /Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/-д ГЗБГЗЗЕГ, аймаг орон нутгийн фэйсбүүк хуудсанд байршуулсан салбарын болон орон нутгийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээлэл, шторкыг хуваалцаж иргэдэд сурталчилдаг. “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын нийтэд ил тод мэдээллэх 87 арга хэмжээний хүрээнд Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn –д тус байгууллагад хамааралтай 48 арга хэмжээг байгууллагын хамаарах хэсэгт хөгжүүлэлт хийж, байршуулсан бөгөөд мөн мэдээ, мэдээллийн	100

						самбарт ил тод байршуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хийгдсэн нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 100 хувьтай дүгнэгдэж, улсын хэмжээнд эхний хагас жилээр “Топ-10” байгууллагаар шалгарсан.	
2.10.1.24	Байгууллагын дотоод болон салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах Хорт код эсэргүүцэгч программ хангамжийн хэвийн ажиллагааг хангах	Урсгал төсөв	Security Certified Хорт код эсэргүүцэгч программ хангамжийн хэрэглэгийн эрх	Техник хангамжийн картын бүртгэлд 15 компьютер бүртгэн үйлдлийн системийг шинэчилж, шаардлагатай программ хангамжийг суулгасан.	Жилийн эцэст: Хорт код эсэргүүцэгч программ хангамжийг байгууллагын бүх хэрэглэгчид ашиглуулж байгууллагын дотоод болон салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна.	Албан хаагчдын ашиглаж буй компьютерт хорт код эсэргүүцэгч программ хангамжийг суулган шинэчлэлтийг тухай бүр хийж, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх тухай зөвлөмжийг өгч ажиллаж байна.	100
2.10.1.25	Байгууллагын албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд буй програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах	Үйл ажиллагаа	Програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа	Техник хангамжийн картын бүртгэлд 15 компьютер бүртгэн үйлдлийн системийг шинэчилж, шаардлагатай программ хангамжийг суулгасан.	Эхний хагас жилд: Байгууллагын албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна. Жилийн эцэст: Байгууллагын албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна.	ГЗБГЗЗЕГ-ын даргын 2022 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн А/160 дугаар тушаалаар батлагдсан “Салбарын мэдээллийн технологийг ашиглах дотоод журам”-ын дагуу байгууллагад ашиглагдаж буй компьютер, түүний дагалдах тоног төхөөрөмжүүдэд бүртгэл үүсгэн, эвдрэл гэмтэл, хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд засвар үйлчилгээг хийн тухай бүр техник хангамжийн карт хөтлөн ажилладаг. Техник хангамжийн картын бүртгэлд 10 компьютер бүртгэн үйлдлийн системийг шинэчилж, шаардлагатай программ хангамжийг суулгасан. Мөн сэлбэх шаардлага үүссэн 3 компьютерт hard болон ram нэмэлтээр суурилуулан	100

						компьютерын ажиллах хүчин чадлыг нэмэгдүүлсэн	
Стратеги төлөвлөгөөний зорилго 2.11. Архивын цахим системээр үйлчилгээ үзүүлэх							
2.11.2	Төрийн архивын түүхийн үнэт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагаа	Цахим системд холбосон, бар коджуулсан баримт	-	50 хадгаламжийн нэгж цахим системд холбон, хадгаламжийн нэгжийн баримтыг бар коджуулна.	Улсын хэмжээний газрын харилцааны салбарын Төрийн архивын цахим мэдээллийн сан /archive.gazar.gov.mn/ болон Төрийн архивын цахим систем /e-document.gov.mn/-д данс, бүртгэлийг бүрэн хөтлөн нийт 343 цахимжуулсан баримтыг бүрэн оруулсан.	100
2.11.2.1	Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх	Үйл ажиллагаа	хадгаламжийн нэгж	2024 оны байдлаар 24 хадгаламжийн нэгжийн баримт цахимжсан.	Эхний хагас жилд: Үүссэн хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын САХ-тэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна. Жилийн эцэст: Үүссэн хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын САХ-тэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна.	2024 оны ХХНЖ-ын дагуу байнга болон 70 жил хадгалах 22 баримтыг цахимжуулан цахим мэдээллийн санг үүсгэсэн. Улсын хэмжээний газрын харилцааны салбарын Төрийн архивын цахим мэдээллийн сан /archive.gazar.gov.mn/ болон Төрийн архивын систем /e-document.gov.mn/-д данс, бүртгэлийг бүрэн хөтлөн нийт 343 цахимжуулсан баримтыг бүрэн оруулсан. Дээрх цахим системд 2024 онд хөтлөгдсөн баримтын мэдээллийн санг 3 дугаар улиралд оруулахаар ажиллаж байна.	70
2.11.2.3	Архивын баримтаар байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох	Үйл ажиллагаа	Цаасан болон цахим баримтын үйлчилгээ	2024 онд 122 хадгаламжийн нэгжийн баримтаар үйлчилгээ үзүүлсэн.	Цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.	Байгууллагын архивт хадгалагдаж буй баримтаар иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэн архиваас олгосон баримтын хуулбарын бүртгэл, дотоод ажлын хэрэгцээнд ашиглуулахаар олгосон баримтын бүртгэлийг тогтмол хөтөлдөг. 2025 оны эхний хагас жилд цаасан болон цахим баримтаар	100

						дотоод ажлын хэрэгцээнд 17 удаа, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 32 удаагийн лавлагаа мэдээлэл өгч үйлчилсэн.	
2.11.3	Түүхийн үнэт баримтыг архивын хосгүй үнэт зүйлд бүртгүүлэх	Бэлтгэл ажил	1963-1990 онд агаараас авсан 1200 банк бүхий 354511 ширхэг гэрэл зургийн хальс төрийн архивт хадгалагдаж байна.	Төрийн архивт хадгалагдаж байна 1963-1990 онд агаараас авсан 354511 ширхэг гэрэл зургийн хальсыг цахимжуулж, хосгүй үнэт баримтад бүртгүүлэх	Хөрөнгө оруулалт Төсөл, хөтөлбөр	Тус байгууллагад түүхийн үнэт баримт байхгүй болно.	100
2.11.3.1	Дансны бүртгэл, хадгаламжийн сангийн өөрчлөлт, хөдөлгөөний бүртгэл хөтлөх, статистик мэдээ тайлан, тоо бүртгэлийг хууль журамд заасан хугацаанд гаргаж АЕГ-т тайлагнах	Үйл ажиллагаа	Мэдээ	Жил бүрийн 12 сарын 1-ний дотор мэдээг хүргүүлдэг	Жилийн эцэст: Архивт хадгалагдаж байгаа баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл болон нэгж талбарын хувийн хэргийн судалгааг загварын дагуу гаргаж 12 дугаар сарын 10-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Архивт хадгалагдаж байгаа баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл болон нэгж талбарын хувийн хэргийн судалгааг 12 сард гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ.	ХБ
2.11.3.5	Аймгуудын ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг сумдаас татан төвлөрүүлэх	Үйл ажиллагаа	Нэгж талбарын хувийн хэрэг	ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдан зааварчилгааны дагуу 481 нэгж талбарын хувийн хэргийн баримтыг цэгцэлсэн.	Эхний хагас жилд: ГЗБГЗЗЕГ-аас өгсөн аргачлал, журмын дагуу нэгж талбарын хувийн хэргийн бүрдлийг хангах талаар 3 сумын Газрын даамлуудад зөвлөмж өгөх. Жилийн эцэст: 3 сумын 2011-2014 оны өмчлөлийн газрын хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Тайлант онд тус аймгийн 3 сумын 2011-2014 онд үүссэн өмчлөлийн газрын нэгж талбарын хувийн хэргийг байгууллагын архивд хүлээн авч төвлөрүүлэхээр ажиллаж байна. Сумдын Газрын даамлуудад нэгж талбарын хувийн хэргийн бүртгэл, бүрдлийг хэрхэн хангах талаар заавар, зөвлөмж өгч, “Газрын даамлуудыг чадавхжуулах” сургалтад байгууллагын архивд нэгж талбарын хувийн хэргийг татан төвлөрүүлэх тухай мэдээлэл хүргэсэн.	ХБ
Стратеги төлөвлөгөөний зорилго 2.12. Төрийн болон албаны нууцын үйл ажиллагааг зохион байгуулах							

2.12.1	Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан ажлын тоо	-	Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах талаарх ажлуудыг зохион байгуулсан байна.	Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг 1 дүгээр улиралд зохион байгуулж 2024 оны ирсэн явсан бичиг мэдээ тайланг архив албан хэрэг хөтлөх журмын дагуу архивлан ажилласан.	100
2.12.1.1	Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх Төрийн болон албаны нууцын тооллого хийх, дүн мэдээг хугацаанд нь явуулах	Үйл ажиллагаа	1 мэдээ 1 тооллого	2023 онд Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр явуулсан үйл ажиллагааны мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. 2023 онд Төрийн болон албаны нууцын тооллого хийх, дүн мэдээг хугацаанд нь явуулсан.	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2025 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээг 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЕГ-ын орон нутгийн тагнуулын салбар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нууц баримттай танилцах иргэний итгэмжлэлийг шинэчлэх, нууцын баталгаа авах, нотлох лавлагаа гаргаж өгөх, гадаад улсад зорчих эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний урьдчилсан мэдүүлгийг авах, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тус тус бүртгэлжүүлж мэдээ тайланг ТЕГ-ын орон нутгийн тагнуулын газар, хэлтэс, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Аймгийн ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийж, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Тагнуулын ерөнхий газрын Дундговь аймаг дахь хэлтсээс 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулсан бөгөөд шалгалтын хүрээнд гарсан зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажилласан. Тухайн ажлын тайланг газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Н/7 тоот албан бичгээр ТЕГ-ын Дундговь аймаг дахь хэлтэст хүргүүлсэн. Мөн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/15 дугаар тушаалаар тооллогын комисс байгуулан ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр тус байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үзлэг тооллого зохион байгуулсан.	100

ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
Стратегийн төлөвлөгөөний зорилго 3.1. Улсын хил шалгалтын ажлыг зохион байгуулах							
3.1.2	Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх	Улсын төсөв	Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах 350 мянган газар зүйн нэр	2019-2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 16 аймгийн 117 сум, нийслэлийн 5 дүүргийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдсэн.	Газар зүйн нэрийг тодруулан тогтоож Улсын Их Хурлаар батлуулж, хаягжуулалтад ашигласан байна.	Тус аймгийн 14 сумын газар зүйн нэрийн мэдээллийн сан хөтлөх ажил 2024 онд бүрэн хийгдсэн.	100
3.1.2.1	Газар зүйн нэрийн мэдээллийн сан хөтлөх	Үйл ажиллагаа	Газар зүйн нэрийн мэдээллийн сан үүссэн сумын тоо	2019-2023 онд 15 сумын газар зүйн нэрийн тодруулалтын мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэсэн.	Аймгийн хэмжээнд газар зүйн нэрийн мэдээллийн санг эрхлэнэ.	2024 онд тус аймгийн 14 сумын газар зүйн нэрийн мэдээллийн сан хөтлөх ажил бүрэн дууссан бөгөөд Адаацаг сумын газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд 2025 оны 06 дугаар сард багтаан “Хануйн цав”ХХК нь хүлээлгэн өгнө.	100
3.1.2.4	Газар зүйн нэрийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах	Урсгал төсөв	1 төлөвлөгөө, Зөвлөлийн 2 удаагийн хурал	2024 онд хурлын төлөвлөгөөг батлуулж, Зөвлөлийн 2 удаагийн хурлыг зохион байгуулсан. Газар зүйн нэрийн зөвлөлийг 15 суманд салбар зөвлөл байгуулсан.	Эхний хагас жилд: Газар зүйн нэрийн зөвлөлийн 2025 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн 1 удаагийн хурлыг зохион байгуулна. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж мэргэжил арга зүйн удирдлагаар хангана. Сүүлийн хагас жилд: Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн 1 удаагийн хурлыг зохион байгуулна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар Баянжаргалан, Дэрэн, Хулд, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын газар зүйн нэрийн зураг хэрхэн ашиглах талаар хурал зохион байгуулсан. Адаацаг сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг гүйцэтгэгч “Хануйн цав” ХХК-д ажил эрчимжүүлэх талаар тус сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлд чиглэл хүргүүлсэн.	100

					Сумын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.		
3.1.2.3	Газар зүйн нэрийг холбогдох хурлаар хэлэлцүүлэх, хяналт шалгалт хийхэд хамтран ажиллах	Үйл ажиллагаа	Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийж дууссан сумын тоо	2024 онд сумын газар зүйн нэрийн тодруулалтыг аймгийн хэмжээнд бүрэн хийж сумын ИТХ-аар хэлэлцүүлсэн.	Эхний хагас жилд: УИХ-аар батлуулах газар зүйн нэрийн жагсаалтыг аймгийн газар зүйн нэрийн салбар зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрийг хүргүүлнэ. Сүүлийн хагас жилд: Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын үр дүнд хяналт, шалгалт хийх Ажлын хэсэгт орж хамтран ажиллана.	Адаацаг сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг гүйцэтгэгч “Хануйн цав” ХХК-д ажил эрчимжүүлэх талаар тус сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлд чиглэл хүргүүлсэн.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тогтвортой газар ашиглалтад чиглэсэн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх							
3.2.1	Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн арга зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	Урсгал зардал	Боловсруулсан аргачлал	Аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал батлагдсан	“Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний аргачлал”, “Газар ашиглалтын тохиромжтой байдал, хэрэгцээт байдлын үнэлгээний аргачлал”-ыг боловсруулж, батлуулсан байна.	“Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний аргачлал”, “Газар ашиглалтын тохиромжтой байдал, хэрэгцээт байдлын үнэлгээний аргачлал”-ын төсөлд санал аваагүй байна.	ХБ
3.2.1.6	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан тайлагнах	Үйл ажиллагаа	15 сум	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилт болон газар олголтын байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.	Эхний хагас жилд: Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнасан байна. Жилийн эцэст: Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнах; Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор цахим системд бүрэн оруулж дууссан байна.	2025 онд аймгийн хэмжээнд нийт 658 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр цахим системд хяналт хийхэд 18 арга хэмжээг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлсэн бөгөөд төлөвлөлт зөрчин олгосон газрын зөрчил байхгүй байна.	100

3.2.1.7	Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах, боловсруулах, дүгнэлт авах, батлуулах, батлагдсан төлөвлөгөөг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.	Үйл ажиллагаа	15 сум	МУ-ын 3Г-ын 2024 оны 92 дугаар тогтоол	Эхний хагас жилд: Газар зохион байгуулалт хийх журмын хугацааг баримтлан сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулах, иргэд, олон нийтээс төлөвлөгөөнд санал авах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах. Жилийн эцэст: Газар зохион байгуулалт хийх журмын хугацааг баримтлан сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, цахим системд байршуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах; 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг аймгийн хэмжээнд хянаж ГЗБГЗЗЕГ-аас дүгнэлт авах, тухайн шатны ИТХ-аар батлуулах ажлыг зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөөг ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна.	Журмын дагуу 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг цахим системд бүрэн үүсгэсэн бөгөөд иргэд аж ахуйн нэгжээс цахимаар болон цаасаар төлөвлөгөөнд санал авч байгаа бөгөөд “Бид иргэдээ сонсож шийднэ” өдөрлөг болон байгууллага, 15 сумын газрын даамлуудын фэйсбүүк хуудсаар санал өгөх заавар зөвлөмжийг иргэдэд ил тод мэдээллэн ажиллаж байна.	100
3.2.1.3	Орон нутгийн онцлогт нийцүүлэн Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмыг боловсруулан, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах	Үйл ажиллагаа	15 сум	Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журам байхгүй	Эхний хагас жилд: Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмын төслийг боловсруулж, хянуулан, санал авах ажлыг зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Журмын төслийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.	Орон нутгийн онцлогт нийцүүлэн “Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журам”-ыг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдийн 1/214 дугаартай албан бичгээр төрийн байгууллага, сумдын Засаг дарга нар, иргэдэд санал авах албан бичиг хүргүүлэн, цахим сайтуудаар нээлттэй санал асуулгыг зохион байгуулсан. Иргэн, ААН байгууллага, төрийн байгууллагуудаас ирүүлсэн	100

						саналуудыг нэгтгэн журмын төсөлд тусгасан ба уг журмыг 6 сард аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.	
3.2.1.8	Сумдын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах	Үйл ажиллагаа	15 сум	2024 онд 3 удаагийн сургалтыг танхимаар зохион байгуулсан.	Улиралд нэг удаа цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан байна. Сургалт зохион байгуулсан тайлан мэдээг тухай бүр тайлагнасан байна.	Сумдын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангахаар 2025 оны 03 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд “Сумдын газрын даамлуудыг чадавхжуулах” танхимын сургалтыг зохион байгуулсан. Мөн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам болон цаг үеийн мэдээллийн талаархи сургалтыг цахимаар 2 удаа зохион байгуулсан.	100
3.2.1.9	Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх.	Үйл ажиллагаа	15 сум	Иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр гаргаж, аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолыг хүргүүлсэн.	Жилийн эцэст: Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр нэгтгэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, тогтоолыг ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна.	Газар зохион байгуулалт хийх журмын дагуу 2026 онд иргэнд өмчлүүлэх газрын саналыг иргэдээс цахим болон цаасан хэлбэрээр авч ажиллаж байна.	ХБ
Стратеги төлөвлөгөөний зорилго 3.3. Геодези, зураг зүйн тухай хуулийг шинэчлэн батлуулах							
3.3.1	Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах,	Үйл ажиллагаа	Геодези, зураг зүйн хуулийн төслийн үзэл баримтлал	Геодези зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан.	Геодези, зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулсан байна.	Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах ажилд санал хүргүүлсэн.	100
3.3.1.2	Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд хэлэлцүүлэх	Үйл ажиллагаа	1 хуулийн төсөл	Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг 2023 онд	Эхний хагас жилд: Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах, сурталчлах, шаардлагатай мэдээ,	Сумдын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангахаар 2025 оны 03 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд “Сумдын газрын даамлуудыг чадавхжуулах”	100

				олон нийтээр хэлэлцүүлсэн.	мэдээллээр хангахад хамтран ажиллана.	танхимын сургалтыг зохион байгуулан геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга, хэлэлцүүлэг зохион байгуулсан.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах							
3.7.1	Хяналт шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардагдах баримт бичгийг шинэчлэн боловсруулах	Үйл ажиллагаа	Шинэчлэн батлагдсан эрсдэлийн шалгуур үзүүлэлт-1 Батлагдсан хяналтын хуудас-1	2024 онд Салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах журам”, “Хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэх, дугаар олгох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулсан.	Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлт, шалгалтад хамрагдах объектыг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, хяналт шалгалтыг үр дүнтэй, ил тод, нээлттэй болгох, аливаа нөлөөллөөс ангид, адил тэгш, хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.	Хяналт шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардагдах хяналтын хуудсыг шинэчлэхэд санал хүргүүлж тус хяналтын хуудас нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын А/115 тушаалаар "35.5 Геодези, зураг зүйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-д нэмэлт өөрчлөлт оруулсан	100
3.7.1.3	Газар, геодези, зурагзүйн хяналтын улсын (ахлах) байцаагч нарт зориулсан чадавхжуулах сургалтад хамрагдах	Үйл ажиллагаа	Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын тоо	Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчдад 2024 онд нийт 3 удаагийн цахимаар болон 1 удаагийн танхимаар сургалтад хамрагдсан.	Батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу чадавхижуулах сургалтад идэвхи, санаачлагатай оролцсон байх.	2025 оны эхний хагас жилийн байдлаар чадавхжуулах сургалт зохион байгуулагдаагүй байна.	ХБ
3.7.1.4	Орон нутгийн хэмжээнд Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн рийл, постер, мэдээ	Үйл ажиллагаа	Батлагдсан төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээний тоо	2024 онд хяналт шалгалтын зөвлөмж 2 постер бэлтгэж иргэдэд сурталчилсан.	Газрын харилцааны салбарт түгээмэл гарч байгаа зөрчлийг бууруулах зорилгоор иргэд, олон нийтэд урьдчилан сэргийлэх рийл, постер, мэдээ мэдээллийг хүргэсэн байна.	2025 оны 6-11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн.	ХБ

	мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэх						
3.7.4	Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх	Үйл ажиллагаа	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол	Засгийн газрын тогтоол, тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар, холбогдох байгууллагуудаас санал ирүүлсэн	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах асуудлын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, холбогдох судалгаа, дүгнэлтийг гаргаж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн байна.	“Хөшигийн хөндий-Чойр-Замын-Үүд” чиглэлийн тусгай зориулалтын авто замын зурвас газрын газар ашиглалтын судалгааг гаргаж уг газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулсан.	100
3.7.4.5	“Хөшигийн хөндий-Чойр-Замын-Үүд” чиглэлийн тусгай зориулалтын авто замын зурвас газрын газрын нөлөөлөлд өртөж буй нэгж талбарын судалгаа, газар ашиглалтын судалгааг нарийвчлан гаргах, сонсох ажиллагааг зохион байгуулах, мэдэгдэл хүргүүлэх, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх	Үйл ажиллагаа	Төв аймаг, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь	Зам тээврийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/155 дугаартай албан бичиг	Эхний хагас жилд: Нөлөөлөлд өртөж буй нэгж талбарын судалгаа, газар ашиглалтын судалгааг нарийвчлан гаргах, иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэл хүргүүлэх, сонсох ажиллагааг зохион байгуулах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх	“Хөшигийн хөндий-Чойр-Замын-Үүд” чиглэлийн тусгай зориулалтын авто замын зурвас газрын газар ашиглалтын судалгааг гаргаж газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулсан бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр саналаа хүргүүлээд байна.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах							
3.7.5	Газрын зөрчил, маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо	2024 онд иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 218 албан бичиг, иргэний 63	Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргах, нотлох баримтыг хүргүүлсэн байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 11 албан бичгийг шийдвэрлэсэн.	100

				өргөдлийг шийдвэрлэсэн.			
3.7.5.1	Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах.	Үйл ажиллагаа	Шийдвэрлэсэн албан бичиг, тушаалын биелэлт	Шинжээчийн дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.	Эхний хагас жилд: Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажлын хэсэг байгуулах тухай газрын даргын тушаалын төсөл боловсруулан, ажлын хэсгийг байгуулсан байна. Шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажлын хэсэг байгуулах тухай газрын даргын тушаалын төсөл боловсруулан, ажлын хэсгийг байгуулсан байна. Шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна.	Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажлын хэсэг байгуулах тухай газрын даргын 2 тушаалын төсөл боловсруулан, 2 ажлын хэсгийг байгуулсан байна. 2 ажлын хэсэг хуралдаж, шинжээчийн дүгнэлтийг гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн.	100
3.7.3.5	Хот тосгон, бусад суурины доторх Авто замын хамгаалалтын бүсийг зураглах, тогтоох ажлыг зохион байгуулан, батлуулах, батлагдсан шийдвэр болон хамгаалалтын бүсийг цахим системд байршуулах.	Үйл ажиллагаа	15 сум	Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар хурлын тэмдэглэлд дурдсан Зам тээврийн яманы ирүүлсэн Авто замын мэдээллийг цахим системд оруулсан.	Эхний хагас жилд: Аймаг, сумын хот, суурины авто замын зурвас газрын өргөнийг холбогдох норм, дүрмийн хүрээнд зураглан, батлуулах ажлыг зохион байгуулах. Жилийн эцэст: Хамгаалалтын бүсийн мэдээллийг цахим системд оруулах ажлыг зохион байгуулах.	Аймгийн засаг даргын 2024 оны А/698 тоот захирамжаар Сайнцагаан сумын төвөөр дайран өнгөрч байгаа 17км автозамын зурвас газрын хамгаалалтын бүсийг тогтоосон бөгөөд хамгаалалтын бүсийг тогтоосон зураглалыг цахим системд байршуулсан.	100
3.7.3.6	Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг холбогдох байгууллагатай хамтран зураглан тогтоон, батлуулах, батлагдсан тогтоол	Үйл ажиллагаа	15 сум	Усны газраас ирүүлсэн усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс	Эхний хагас жилд: Аймаг, сумын нуур, гол мөрний онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоон зураглах, хамгаалалтын бүсийг ИТХ-аар батлуулах. Жилийн эцэст:	Аймгийн хэмжээнд 2024 онд усны тооллого хийгдсэн бөгөөд 188 булаг, 80 нуур, 5 рашааны судалгаа гарсан эдгээрийн хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг ИТХ-аар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	100

	шийдвэр болон хамгаалалтын бүсийг цахим системд байршуулах.				Хамгаалалтын бүсийн тогтоол шийдвэр, цахим системд байршуулсан байх.		
3.8.1	Доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг тодорхойлох болон түүнийг нөхөн сэргээх журам, аргачлал, зааврыг боловсруулж хэрэглээнд нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах	Үйл ажиллагаа	Газрын багц хуулийн төсөл, түүний үзэл баримтлалын төсөлд тусаж, батлагдсан заалтын тоо, Шинээр боловсруулж баталсан доройтсон газрыг тодорхойлох, түүнийг нөхөн сэргээх журам, аргачлал, зааврын тоо	ЗГ-ын 2024 оны 92 дугаар тогтоолоор “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам” батлагдсан. Доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг тодорхойлох болон түүнийг нөхөн сэргээх аргачлалын төсөл боловсруулагдсан.	Доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг тодорхойлох болон түүнийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд хариуцах этгээдүүд тодорхой болж, хийж гүйцэтгэх ажил, үе шат ойлгомжтой, салбар хоорондын уялдаа холбоо сайжирч, газар хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоо бүрдсэн байна.	Аймгийн хэмжээнд доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг тодорхойлж, нөхөн сэргээх арга хэмжээ авах шаардлагатай уул уурхайн 6.5га, бэлчээрийн 4га газрын төлөвлөгөөг батлуулж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2/252 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	100
3.8.1.1	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Бэлчээрийн фото мониторингийн цэгийн тоо	2024 онд 21 аймгийн 319 сум, нийслэлийн 6 дүүргийн бэлчээрийн газарт фото мониторингийн ажлыг зохион байгуулж, 247 цэгийн мэдээллийг шинэчлэн бүрдүүлж, улсын хэмжээний нэгдсэн тайлаг гаргасан.	Жилийн эцэст: 2025 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан нэгтгэж, холбогдох зөвлөмжийг гаргаж, газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг 10 сарын 01-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг 8 дугаар сард зохион байгуулна.	ХБ
3.8.1.2	Атар газраас тариалангийн ангилалд шилжүүлэх саналыг судлаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санал, дүгнэлт боловсруулах	Үйл ажиллагаа	Ирүүлсэн саналын тоо	“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын	Эхний хагас жилд: Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна. Жилийн эцэст: Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан	Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэрт харьяагдах 524 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх саналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжилан Засгийн газрын 2025 оны 166 дугаар	100

				хэрэгжилтийг гаргаж, тус газрын 2024 оны 1/2901 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.	бичгийг судлан шийдвэрлэсэн байна.	тогтоолоор тариалангийн газарт шилжүүлсэн.	
3.8.1.3	Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг боловсруулж хүргүүлэх	Үйл ажиллагаа	Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайлан	Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан хэвлэгдсэн.	Эхний хагас жилд: Газрын нэгдмэл сангийн 2024 оны улсын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд Газарт учирсан хохирлын ГНСТ-9 тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ГНСТ-10 тайланг нэгтгэн гаргаж, ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байна.	Газарт учирсан хохирлын ГНСТ-9 тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ГНСТ-10 тайланг нэгтгэн гаргаж, 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/29 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	100

ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
4.1.1	Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухай бүр	Хэрэгжилтийг ханган ажилласан.	Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.	Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: - Сул орон тооны захиалгыг ТАСЗ-д 2 удаа хүргүүлж, төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 иргэнийг ТАСЗ-ийн тогтоолын дагуу холбогдох албан тушаалд томилж, сул орон тоо 7 байсныг 5 болгож бууруулсан. - Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээрээ “А” үнэлгээтэй дүгнэгдсэн 11 албан хаагчийн ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв ахиулж, зэрэг дэв шинээр олгосон. - Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, -дүгнэн 1,2 дугаар улирлын мөнгөн урамшуулал олгосон. - “Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба” аяны хүрээнд байгууллагын хүний нөөцийн түгээн дэлгэрүүлэх сайн туршлагын талаар бусад төрийн байгууллагын албан хаагч нарт мэдээлэл хийсэн. , Тс байгууллагын сул орон тооны талаарх мэдээллийг видео хэлбэрээр бэлтгэж байгууллагын пэйж хуудсанд байршуулсан. Мөн	100

						сул орон тооны мэдээллийг гарын авлага хэлбэрээр боловсруулж, 8 суманд зохион байгуулсан “Бид иргэдээ сонсож шийднэ” өдөрлөгийн үеэр 650 иргэнд тараасан. - Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хүний нөөцтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, хэрэгжилтийг байгууллагын фэйсбүүк хуудас, пэйж хуудас болон мэдээллийн самбарт олон нийтэд ил тод байршуулсан. Албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх зүйлд заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллаж байна.	
4.1.1.1	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухай бүр	Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан.	Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээрээ “маш сайн”, “хэвийн” үнэлгээтэй дүгнэгдсэн албан хаагчдын ажилласан жил, ур чадварыг харгалзан шаардлага хангасан нийт 11 албан хаагчийн (10 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 1 албан хаагчид зэрэг дэв шинээр олгуулах) материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Төрийн захиргааны нийт 28 албан хаагчтайгаас 18 албан хаагч буюу 70 хувийг зэрэг дэвтэй албан хаагчид эзэлж байна.	100

4.1.1.3	Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Сул болон эзгүй орон тоо	Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан.	Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна.	- ТА3-ийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу тус байгууллагын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах ажлын байрны жагсаалтыг ТАС3-д 2 удаа хүргүүлж, сул орон тоо 7 байсныг 5 болгож бууруулсан. Тус аймагт 4 сумын Газрын даамлын орон тоо сул байгаа ба Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтын дагуу Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд Газрын даамал албан тушаалын чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байна. - “Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба” аяны хүрээнд Их дээд сургууль төгсөж байгаа оюутнууд дунд судалгаа хийж хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчнийг нэмэгдүүлэх талаар ХААИС-ийн багш нартай уулзалт зохион байгуулсан. Мөн орон нутагт салбарын боловсон хүчний нөөц бүрдүүлэх зорилгоор “Мэргэжил сурталчлах өдөрлөг” арга хэмжээг 3 дахь жилдээ санаачлан зохион байгуулж байна. Сул орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/ пэйж хуудас болон мэдээллийн самбарт	100
---------	---	---------------	--------------------------	--	--	--	-----

						нийт 6 удаа шинэчлэн байршуулж, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээллэсэн. - 2025 онд Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан хаагч байхгүй болно.	
